

Монголын музейн хөгжлийг үечлэн үнэлэх нь

Сүндэвийн Энхнаран 

Соёл урлагийн их сургуулийн харьяа Соёл, урлаг судлалын хүрээлэн,
Улаанбаатар, Монгол Улс
✉ bbe3mn@gmail.com

Хураангуй: Судлаачид монголын музейн түүхийг музейн үүсэл, сан хөмрөгийн бүрдүүлэлт, арга зүй, судалгааны чиг үүрэг, хөгжил зэргийг харгалзан олон янзаар үечлэн тайлбарласан байдаг.

Музейн талаарх бодлогын баримт бичиг, эрх зүйд үндэслэж, судлаачдын дурдсан судалгааны үр дүнг харгалзан музейн судлалын онол, үзэл баримтлалын үүднээс монголын музейн хөгжлийг үечилж авч үзсэн. Ингэхдээ сан хөмрөгийн бүрдүүлэлт, судалгаа, харилцаа, боловсрол буюу ССХБ-ын дөрвөлөөр шалгуур үзүүлэлт болгон музейн хөгжлийг тайлбарлав.

Түлхүүр үгс: *музейн талаарх бодлого, чиг үүрэг, сан хөмрөгийн бүрдүүлэлт, судалгаа, харилцаа, боловсрол*

A periodic evaluation of the Development of Museums in Mongolia

Enkhnaaran Sundev 

The Research Institute of Culture and Arts, Mongolian National University
of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia
✉ bbe3mn@gmail.com

Abstract: Researchers have interpreted the historical development of Mongolian museums by various periods, considering factors such as history, collection, preservation, methodology, functions, and evolution. Based on museum policies and legal frameworks, and through the lens of museological theory and principles, this study categorizes and assesses the development of Mongolian museums. The evaluation employs the PRCE model—Preservation, Research, Communication, and Education—to analyze museum development.

Keywords: *museum policy, function, preservation, research, communication, education*

Оршил

Улс орны эрх ашиг, хүний бүтээлч сонирхлоор дэлхийн ховор сонин, этгээд содон зүйлс, урлагийн бүтээл, баялаг хөрөнгө, үнэт эдлэлээ өөрийн нутаг орон, хувийн эзэмшил эдлэн, кабинетад хураан цуглуулах, бусдад дэлгэн үзүүлэх ажлаас

улбаалж анх үүссэн музейнүүдийн үзэл баримтлал, чиг үүрэг нь хүн төрөлхтний хөгжил дэвшилтэй зэрэгцэн хувьсан өөрчлөгдөж, өргөжин хөгжих зүй тогтолтой юм. XVIII зууны дунд үеэс, өрнөдөд суралцсан дорно (япон, хятад)-ын сэхээтэн, оюунлаг элч, төлөөлөгчид Дэлхийн үзэсгэлэнд тогтмол оролцсоноор өөрсдийн улс орондоо соёл, уламжлалаа хадгалан хамгаалах үзэл баримтлалтай музей үүсэн байгуулагдахад чухал үүрэг гүйцэтгэсэн байдаг. Өдгөө эдгээр орнуудын музейд сан хөмрөгтэй байх, соёлын биет болон биет бус өвийг хадгалан хамгаалах, боловсролын, нийгмийн үүрэг, хариуцлага хүлээх, тогтвортой хөгжил, экомүзей хөгжүүлэх зэргээр үзэл баримтлал, чиг хандлагууд хөгжиж байгаа билээ. Үүний зэрэгцээ Япон, Хятад, Солонгос орон дахь улсын болон үндэсний томоохон музейнүүд шинжлэх ухаан, технологийн өндөр хөгжлөөр музейн сан хөмрөг, судалгаа, харилцаа, үзэсгэлэн, боловсрол, тайлал, тайлбарын бүхий л үйл ажиллагааг шийдвэрлэн олон нийт, жуулчдын анхаарлын төвд, нэр хүндтэй, алдар цуутай байдаг бол бүс, бүлэг, орон нутаг, сонирхол хувийн цуглуулга, сан хөмрөгт түшиглэсэн музейнүүдийн үйл ажиллагаа ихэвчлэн орон нутгийн зөвлөл, нутгийн иргэдийн оролцоо, хамтын ажиллагааны хүрээнд өв соёлоо хадгалан хамгаалж, олон нийтэд үйлчлэх, соён гэгээрүүлэх, үүрэг хүлээн ажиллаж байна.

Музей бол биет болон биет бус өвийг судлах, цуглуулах, хадгалах, тайлбарлан таниулах, дэлгэн үзүүлэх зорилготой ашгийн бус, нийгэмд үйлчилдэг институт (байгууллага) юм. Олон нийтэд нээлттэй, ялгаатай хэрэгцээнд хүртээмжтэй, байгаль экологи, тогтвортой байдлыг дэмжиж ажиллана. Ингэхдээ музей нь боловсрол, сэтгэл ханамж өгөх, эргэцүүлэн бодох, мэдлэг хуваалцах төрөл бүрийн үйл ажиллагааг нийгмийн бүлгийн оролцоо, мэргэжлийн ёс зүйтэй харилцаанд тулгуурлаж явуулдаг байх хэрэгцээ шаардлага өнөөгийн музейнүүдэд тавигдаж байна.

Ямарваа нийгмийн тогтолцоонд музей тэргүүтэй нийгмийн институт нь тухайн нийгмийн хөгжил дэвшил, хувьсал өөрчлөлтийн хүчин зүйлсийн нэг нь болдог. Холбогдох хууль эрх зүйн үзэл баримтлал, бодлогоор музейн хөгжил, үзэл баримтлал, чиг үүргийг баримжаалан тодруулж болох бөгөөд музейг нийгэм, хүний амьдралын чанарыг сайжруулдаг хүч (*power*) болгон цаашид хөгжүүлэх боломжтой билээ.

Судалгааны эх хэрэглэгдэхүүн, арга зүй

Музейн хөгжлийн чиг баримжаа, хэтийн төлөв, үйл ажиллагаа зэргийг зохицуулсан Улсын Их Хурал, Ардын их хурлын тэргүүлэгчид (АИХТ), Сайд нарын зөвлөл (СнЗ), Монгол ардын хувьсгал намын Төв хороо, Улс төрийн товчоо (МАХН ТХ, УТТ), Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, яамд, хэрэгжүүлэгч агентлаг, хорооноос, 1918-2023 онуудад баталж хэрэгжүүлсэн музейн талаарх хууль, эрхзүйн гурван зуу найм (308) баримт бичигт музей судлалын ангиллыг буулгаж, утга нөхцөл байдлыг эргэцүүлэх, тайлан тайлбарлах аргыг ашиглав. Ингэхдээ Үндсэн хууль, бодлогын баримт, байгууллага, хүний нөөц болон П.Меншийн *PRC*, ЮНЕСКО-гийн зөвлөмжийн тодруулга *PRCE*-н онолоор цуглуулсан эх хэрэглэгдэхүүнд (Хүснэгт 1) чиг үүрэгдүүлэн шинжилсэн.

Хүснэгт 1. Музейн талаарх хууль, эрх зүйн баримт

Төрөл	Үндсэн хууль, бодлогын баримт	Байгуул- лага	Хүний нөөц	Сан хөмрөгийн бүрдүүлэлт	Судалгаа	Харилцаа (Боловсрол)
Тоо	12	94	23	115	25	39
Нийт	308					

Сан хөмрөгт суурилсан музейн сан хөмрөгийн бүрдүүлэлт, судалгаа, харилцааны чиг үүргийн тэнцэл музейн чадавхыг сайжруулж, нийгмийн институт болгодог. Үүнийг П.Менш хэрэглээний музей судлалд музейн удирдлага, сан хөмрөгийн бүрдүүлэлт, судалгаа, харилцаа (Maroevic 1998, 19) хэмээн багтаасан байдаг. Үүнийг сан хөмрөгийн бүрдүүлэлт (*Preservation*), судалгаа (*Research*), харилцаа (*Communication*)-г музейн чиг үүрэг гээд ССХ (*PRC*)¹ загварт багцалсан. Хожим ЮНЕСКО Меншийн *PRC* онолд үндэслэж “Музей, сан хөмрөгийг хамгаалах, сурталчлах зөвлөмж” (2015) боловсруулахдаа харилцаанаас боловсрол (*Education*)-г тодруулан нэмээд, ССХБ (*PRCE*)-ийн дөрвөлөөр гишүүн орнуудын холбогдох эрхзүй бодлогыг шинжилж, тус зөвлөмжийнхөө хэрэгжилтийг судалж тайлагнасан (UNESCO 2015, 28, 65) байдаг.

Судалгааны үр дүн

Монголын музейн мэргэжилтэн, судлаачид музейн түүхэн хөгжлийг нийгмийн өөрчлөлт, шилжилт, музей үүсэл, хөгжил, тогтолцоо, шинэчлэл, чиг үүргээр үечилсэн байдаг. Үүнд:

1. Ө. Бүрнээ (1994)
 - 1921-1940 онд анхны музейнүүд үүссэн үе
 - 1940-1960 онд орон нутаг судлах, тусгай дурсгалын болон түүх-хувьсгалын музейнүүд бий болсон,
 - 1960-1990 онд нийт төрөл мэргэжлийн музейнүүд үүсэж бэхжин тохижсон буюу музейн хөгжил дэвшлийн үе
2. Д. Цэдмаа (1997)
 - 1924-1940 онд анхны музейн байгууллага бий болсон,
 - 1940-1960 онд музейн тоо олширч, үзмэр цуглуулгын ажил далайцтай өрнөж, сан хөмрөг бүрдэж эхэлсэн,
 - 1960-1990 онд музейн ажлын арга зүйг музейн үйл ажиллагаанд нэвтрүүлэх, мэргэжлийн сэтгүүл хэвлэгдсэн
3. Ц.Цэндсүрэн (2005)
 - 1842-1924 онд монголд музей үүсэж хөгжсөн,
 - 1924-1974 онд музейн тогтолцоо бүрэлдэн тогтсон,
 - 1974-1990 онд музейн тогтолцоо бэхжин хөгжсөн,
 - 1991 оноос одоог хүртэл ардчилал шинэчлэлийн үеийн музейн үе
4. Д.Бумаа (2010)
 - 1924-1956 онд музейн тогтолцооны өмнөх үе

¹ Музей судлалын тулгуур ойлголт (2013. 28)-д “сан хөмрөг үүсгэх, судалгаа хийх, олон нийттэй харилцах” гэж орчуулсан.

- 1956-1990 онд музей тогтолцоо бүрэлдсэн үе
- 1990 оноос тогтолцоо задарснаас хойших
- 5. Соёл урлаг судлалын хүрээлэн (2013-2015)
 - Олноо өргөгдсөн Монгол улс 1921-1923
 - БНМАУ 1924-1991
 - Монгол улс 1992-
- 6. Д.Сүхбаатар (2014)
 - 1921-1924 онд Музей байгуулах бэлтгэл ажлыг хангах үе
 - 1924-1940 онд Музейн хөгжлийн эхэн үе
 - 1940-1960-аад оны эхэн үед Төрөлжсөн музейн музейнүүд болон орон нутгийг судлах кабинетуудыг бий болсон үе
 - 1960-1990 онд Орон нутгийн музейнүүдийн хөгжил төлөвшлийн үе
 - 1990-2012 онд Нийгэм, эдийн засгийн шилжилтийн үеийн музей
 - 2012 оноос Шинэчлэлийн үеийн музей
- 7. Д.Энхтөгс (2014)
 - 1924-1948 онд Музейн үүсэл хөгжлийн эхний үе
 - 1949-1976 онд Орон нутаг судлах музей, кабинетын үе
 - 1980-1990 онд Музейн төрөл чиглэл олширсон үе
 - 1991 оноос Музей судлалын шинжлэх ухааны онолоор, үндэслэлтэй төрөлжүүлэн хөгжүүлэх, музейнүүдийн бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт оруулж, ижил нэг загварын музейг өөрчилсөн үе хэмээн тус бүр үечилсэн.

Ө.Бүрнээ, Соёл урлаг судлалын хүрээлэн, Д.Сүхбаатар, Д.Энхтөгс нар музейн сан хөмрөг цуглуулах, бэлтгэх ажлыг оруулан 1921-1924, олон нийтэд үүд хаалгаа нээж, анхны музейнүүд байгуулсан 1924-1940, орон нутгийн музейнүүд байгуулсан 1940-1960, төлөвшил хөгжлийн үе 1960-1990, шинэчлэлийн зэргээр үечилсэн бол Д.Цэндсүрэн, Д.Бумаа нар музейн үүсэл хөгжил, тогтолцооны үйл явцаар, Д.Цэдмаа анх удаа музейн чиг үүрэгт үндэслэж, сан хөмрөг, арга зүй, судалгааны чиг үүргийг харгалзан үечилсэн байна. Тэр бээр музейд нөлөөлөх нийгмийн хүчин зүйлс, музейн тоо, төрөл, зохион байгуулалт тогтолцоо, ялангуяа музейн онол, арга зүйгээр чиг үүрэг үйл ажиллагааг тодорхой авч үзжээ.

Хэлэлцүүлэг

Монголын музейн чиг үүрэг (сан хөмрөгийн бүрдүүлэлт, судалгаа, харилцаа, боловсрол)-ээр төрөлжүүлэн практикт буулгаж, өмнө дурдсан судлаачдын саналд тулгуурлан хөгжлийг тодруулан (Зураг 1) дахин үечиллээ. Үүнд:

- 1921-1940 он музейн үүсэл, хөгжлийн эхэн үе
- 1940-1970 он орон нутгийг судлах кабинетууд, ОНС музейнүүд бий болсон үе
- 1970-1990 он музейн салбар бэхэжсэн үе
- 1990-2000 он нийгмийн өөрчлөлтийн үе
- 2000 оноос хойших үндэсний музейн хөгжлийн үе

Музейн үүсэл, хөгжлийн эхэн үе (1921-1940 он): Улаанбаатар хотод Улсын музей, Хувьсгалын музей, Шашны эсэргүү музей байгуулж, Богд хааны ордон,


Чойжин ламын сүмийг музей, Эрдэнэзуу хийдийг улсын хамгаалалттай болгов. Улсын музейд ховор сонин зүйлийг хурааж Богд хааны цуглуулгаар баяжуулан 1924 онд олон нийтэд үүд хаалгаа нээв. Музей ховор сонин, элдэв зүйлсээ байр сууцанд дэлгэн тавих, үзүүлэх, нэрийн тайлбар, “ерөнхий ба туслах данс, товч тайлбар, төрөл ангийн нэр дугаар, пайз тусгай тэмдэглэл” (Сүхбаатар 2014, 29)-ийн ажлууд эхлүүлэн гүйцэтгэж байв. БНМАУ-ын Үндсэн хууль (1924)-д “хязгаарын дотор бүх газар ба, уурхай хийгээд ой мод усны ба, мөн тэдгээрийн баялгууд болбоос ...энэхүү хөрөнгө бүрэн ардын мэдэлд байваас зохих бөгөөд, энэ тухай хувийн өмч байгуулж үл болмуй” хэмээн музейн байгууллагыг зөвхөн төрийн хэвшил байхыг заасан байдаг.

Орон нутгийг судлах кабинетууд, ОНС музейнүүд бий болсон үе (1940-1970 он): Хязгаарын цэргийн хаалттай музей, Улаанбаатар хотын музей, чекистийн кабинет, Лениний музей, аймгуудад орон нутаг судлах кабинетууд байгуулж, ажлыг сайжруулахдаа музейн барилга, сан хөмрөг, хүний нөөцийн шалгуур үзүүлэлтээр орон нутаг судлах музейнүүд болгов. Тухайн үед музейн зорилгыг “манай ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн, МАХН-ын удирдлагаар тус оронд мандсан ардын хувьсгалын ялалт, БНМАУ-ын капиталист бус хөгжил, Социалист бүтээн байгуулалтын ололт амжилт манай ард түмнээс ЗХУ болон социалист бусад орны ард түмэнтэй тогтоосон ах дүүгийн найрамдлын үр шимийг түүх соёлын дурсгалт зүйл, байгалийн баялгийн дээж дээр тулгуурлан харуулж, ертөнцийг үзэх материалист үзэл, социалист эх оронч, пролетарийн интернационалч үзлээр хөдөлмөрчдийг хүмүүжүүлэх тэдний соёл шинжлэх ухааны мэдлэгийг дээшлүүлэх явдал мөн” гэж тодорхойлсон. Музейнүүд байгаль, нийгэм, соёл, угсаатны зүйн сан хөмрөг үүсгэн баяжуулах ажлууд эрчимтэй хөгжиж, хамгаалалт, данс тооллогын ажил эхлүүлж байв. Ард олонд сан хөмрөгөө дэлгэн үзүүлэхийн зэрэгцээ үзмэрийн түүх судалгаа хөгжиж, эрдэм шинжилгээний сэтгүүлийн эхлэл тавигдав. Хотын музейнүүдэд орон нутгийн музейн ажилтныг сургах сургалт, семинарыг 10 хоногоос нэг сарын хугацаатай зохион байгуулж байв. Улсын төв музейн дотоод бүтцийг Газар зүй анги, Ургамал, амьтны аймаг анги, Геологи, палеонтологи анги, Түүхийн эрдэм шинжилгээний анги хэмээн зохион байгуулж, бусад музейнүүдэд эрдэм шинжилгээ, арга зүйн чиглэл өгөх үүрэгтэй ажиллуулж байв. Сүхбаатар, Чойбалсан, Шашныг эсэргүүцэх музейнүүдийг байгуулж, татан буулгав.

Музейн салбар бэхэжсэн үе (1970-1990 он): Музейнүүдийн үзэсгэлэнгийн ажил өргөжин олон улсад аялуулах, үзэсгэлэн хүлээж авах, соёл, олон түмний гэгээрлийн ажлууд, сан хөмрөгийн тоо бүртгэл, тусгай тэмдэг зүүх, хяналт, судалгаа, худалдан авалтаар баяжуулах, дүрэм, үнэ тогтоох зэргээр үзэсгэлэн, хадгалалт, баримтжуулалтын ажилтай уялдан мэргэжлийн хэрэгцээ шаардлага өсөн нэмэгдэж байлаа.

Соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль (1970.10.12), сан хөмрөгийн хадгалалт, тусгай бүртгэл, худалдан авах солилцооны зэрэг эрх зүйн зохицуулалттай болов. Музей удирдах газрыг эрт, шинэ үеийн түүх болон угсаатны зүйн, БНМАУ-ын шинэхэн түүхийн, БНМАУ-ын ерөнхий ба эдийн засаг газар зүй, геологи, палеонтологийн, БНМАУ-ын ургамал, амьтан судлалын, БНМАУ-ын урлаг судлал, шашингүйн суртал нэвтрүүлгийн, Марксизм, Ленинизмийн сектор

гэсэн бүтцээр зохион байгуулав. Музей удирдах газар музейнүүдийг мэргэжлийн чиглэл, удирдамж, арга зүйгээр ханган ажиллаж, музейн эрхлэгч, сан хөмрөгч, тайлбарлагчдыг социалист системийн улс орнуудын музейд танилцах дадлага хийлгэж байв. Хувьсгалын музей, Лениний музей, Алтанбулаг дахь Сүхбаатарын музейн байрыг шинэчилж, Дүрслэх урлагийн музей, Уран зургийн галерей, Театрын музей, (Цэрэг) Жуковын гэр музей байгуулж, Монгол Улсын их сургууль, Төмөр зам, Эрдэнэт үйлдвэр, Хөдөө аж ахуйн их сургууль нь байгууллагын доторх музейнүүд байгуулав. БНМАУ-ын Үндсэн хууль (1960)-д “удирдан чиглүүлэгч хүч бүхнийг ялагч марксист-ленинист онолыг үйл ажиллагаандаа” баримтална хэмээн зааж, музей эрхлэх онолын суурийг тавьсан.



Зураг 1. Музейн хөгжил (сан хөмрөг, судалгаа, харилцаа, боловсрол) цаглавар

Нийгмийн өөрчлөлтийн үе (1990-2000 он): Нийгэм, эдийн засгийн хямралд музейнүүд үйл ажиллагаа, сан хөмрөгөө авч үлдэх сорилттой тулгарч, музейнүүдийг төрөлжүүлэх, нэгтгэх, хуваах, салбарлах, татан буулгах болов. Музейн олон нийтэд зориулсан соёл, гэгээрлийн ажил эрс цөөрч, тасалдав. Музейн хүний нөөц, сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалтын бэрхшээлтэй асуудлыг мэргэжилтэн бэлдэх сургалт, олон улсад үзэсгэлэн түрээслэх зэргээр шийдвэрлэхийг хичээж байв. Улсын төв музейн сан хөмрөгийг байгаль, нийгмийн чиглэлээр хувааж, Байгалийн түүхийн, Үндэсний түүхийн музейг байгуулав. Урлагийн, ордны музейнүүд болон сүм хийдийг нэгтгэж Шашны түүхийн музейг хоёр удаа, Шашны урлагийн музейг нэг удаа байгуулж, татан буулгав. Мөн Лениний музей, Хувьсгалын музейг татан

буулгав. Орон нутаг судлах музейнүүдийг аймгуудаар нэрлэж, музейн мэргэжилтэн бэлдэх, музейн сан хөмрөгийн хөдөлгөөн, зөөж тээвэрлэх хилийн зөвшөөрөл, үзмэрийг зэрэглэл, үнэлгээний зэрэг зохицуулалтын ажлуудыг эхлүүлэв. Энэ үед Улс төрийн хэлмэгдэгсдийн музей, Цэргийн түүхийн музей олон нийтэд үүд хаалгаа нээв. Монгол Улсын Үндсэн хууль (1992)-д “төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөх” хэмээсэн нь музей хөгжүүлэх үзэл баримтлал болон төлөвшиж байна.

2000 оноос хойших үндэсний музейн хөгжлийн үе: Музейнүүд монголын түүх, археологи, соёл, байгалийн өвийн үзэсгэлэнгээр олон нийт, жуулчдад үйлчлэх, түүхэн тэмдэглэлт ой тэмдэглэх, Монголын уламжлалт сэтгэлгээ, арга билгийн ухааны үндэс, Морин хуур, Монгол хөөмий, Чингис хааныг дээдлэх, Уртын дуу, Эрдэнийн судраас суралцах зэрэг хүүхэд багачуудад зориулсан боловсролын, эрдэм шинжилгээний сэтгүүлийн ажлууд тогтмолжсон. Олон улсад монголын түүх, соёлын өв, ялангуяа Чингис хааны сэдэвтэй үзэсгэлэн аялуулан түрээсэлж байв. Гадаадын хөрөнгө оруулалтаар сан хөмрөг, сэргээн засварлах, мэргэжил дээшлүүлэх, суралцах, арга зүйн гарын авлага хэвлүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх хамтын ажиллагааны хүрээнд музейн харилцаа, боловсрол, сан хөмрөг баяжуулах түүх, археологийн судалгааны сонирхол өсөн нэмэгдэж байна. Музейн тухай хууль (2021), музей судлаачидтай болж, сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт, хувилах, олшруулах, зэрэглэх, сэргээн засварлах, тоон мэдээллийн сантай болох, мэргэжлийн ажиллагчид, үзмэртэй шууд харьцах албан тушаалтныг тодорхойлох зэрэг зохицуулалтыг эрх зүй, төсөл, хөтөлбөрүүдээр хэрэгжүүлж, мэргэжлийн орчин, нөхцөлийг сайжруулж байна. Музейн дотоод бүтэц, зохион байгуулалтыг захиргаа, эрдэм шинжилгээ, арга зүй, сан хөмрөг, олон нийт, боловсрол, аюулгүй байдал, үйлчилгээний хэсэг, алба хэмээх хандлагатай болж байна.

Монголын Үндэсний музей (2008), Чингис хаан Үндэсний музей (2021), Байгалийн шинжлэх ухааны үндэсний музей (2023)-г байгуулав. Үндэсний музейд улсын тулгуур бодлого, үзэл баримтлалын тусгал их, холбоо хамааралтай байна. Иймд үндэсний музейгээс улсын түүх, соёлыг танин мэдэх боломжтой, улс орны хөгжлийн нүүр царай болж хөгждөг. Эл онолыг музей судлаачид төр бий болоход нөлөөлдөг хоёр хүчин зүйл байх бөгөөд нэгдүгээрт, цэрэг дайны нөлөөлөл, хоёрдугаарт, үндэсний өөрчлөн байгуулалт буюу модернизац гэж тайлбарласан. Хоёр дахь хүчин зүйлийн нөлөөн дор үндэсний музейн бүтээн байгуулалт холбогддог. Үндэсний музейд улсын тулгуур үзэл баримтлал, хөрөнгө оруулалт, үндэстний түүх, соёл томоохон байр суурьтай байдаг (Aronsson 2011, 43-44) гэжээ. “Монголын энх тайван ба түүхэн туршлага” сэдэвт Олон улсын Монголч Эрдэмтний XII Их хуралд Урадын Булаг (Их Британи) *The Chinggis Khaan National Museum as a Model of Decolonisation* илтгэлдээ монголчууд Ковидын хямралын үеэр Чингис хаан Үндэсний музейгээ эзлэн түрэмгийлж байсан улс орноос олзолж, булааж, дээрэмдэж, хулгайлж авчирсан нэг ч эдийн соёл, дурсгалгүйгээр байгуулж чадлаа. Энэ нь өнөөгийн өрнөдийн “шүдний өвчин” болж буй “музейн диколончлолын” сонгодог загвар болж байна гэж дүгнэсэн.² Мөн цуглуулгын хадгалалт, хамгаалалт,

² Хурлын тэмдэглэл (2023.08.12)

зай талбай нэмэгдэх, сэргээн засварлах лаборатори гээд сан хөмрөг бүрдүүлэлтийн олон тулгамдсан асуудлыг шийдвэрлэсэн байдаг.

Үүнээс гадна түүх, археологийн дурсгалт газрыг түшиглэн Хархорум музей, Хөшөө цайдам музей байгуулав. Улаанбаатар их сургууль Археологийн музей, Онцгой байдлын албаны музей, Цагдаагийн музейг байгууллагын дотор байгуулж, хувийн цуглуулагчид сан хөмрөгөө дэлгэн үзүүлэх, музейтэй болох сонирхол өсөн нэмэгдэж байна. Хууль бусаар хил гарсан Батаарыг эргүүлэн буцаасны үр дүнд Үлэг гүрвэлийн музей байгуулж, удалгүй татан буулгав.

XX зуунд, Шинжлэх ухааны хүрээлэнгийн орон нутаг судлах түшиц газар болгон аймгуудын музейг байгуулсан нь ардын уламжлалт аж ахуйгаас гаралтай бүтээгдэхүүн инновацлах, үйлдвэрт нэвтрүүлэх, лабораторийн судалгаа хийх, өрхийн амьжиргааг дэмжих, байгаль экологи, уур амьсгал өөрчлөлт, экомүзейг хөгжүүлэх, бүсчлэн хөгжүүлэх зэргээр шинжлэх ухаанчаар орон нутаг хөгжих өнөөгийн оновчтой гаргалгаа байсныг үгүйсгэх аргагүй, эргэн харах шаардлагатай баримт юм.

Монгол Улсын төр, засгийн газар музейг монголчуудын эрт эдүгээгийн түүх, соёл, дурсгалыг хадгалан хамгаалж, ирээдүй хойч үедээ өвлүүлэх, олон нийтэд танин мэдүүлэх нийгмийн үүрэг бүхий төрийн үйлчилгээний байгууллага хэмээн тодорхойлж, зах зээлийн нийгэмд шилжсэн нь нэг талаас музейн олон үйл ажиллагааг ардчилсан, чөлөөт мэт болгож байгаа мэт боловч нөгөө талаас музей судлал, музейн харилцаа болон цуглуулгын менежмент, хүний нөөц зэрэг олон асуудалд тулгамдаж буй нь тод харагдаж байна. Ялангуяа нийгмийн ажилгүйдэл, ядуурал, хүний буруутай үйл ажиллагаа, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор сан хөмрөг, цуглуулгын хадгалалт эмзэг болжээ.

Цаашид бакалавр, магистр, докторын сургалтын хөтөлбөрөөр музейн судалгааг хөгжүүлэн түвшин ахиулж суралцах, музейд ажиллаж буй багш, ургамал судлаач, түүхч, археологич зэрэг мэргэжилтэй ажилтанд музей судлалын сургалтын кредит цуглуулах зэргээр сургалтын олон хэлбэрийг дэмжих хэрэгтэй байна. Ялангуяа ахисан түвшний сургалтын судалгааг музейн түүх бичлэг, ерөнхий, шинэ, нийгэм (үүрэг, хариуцлага, тогтвортой байдал, ёс зүй, төлөөлөл, тайлал, г.м)-ийн, эко, тусгай (түүх, угсаатан, археологи, антропологи, геологи, биологи, палеонтологи, г.м), хэрэглээ (удирдлага, маркетинг, сан хөмрөг, материал судлал, хадгалалт, сэргээн засварлалт, бүртгэл мэдээлэл, харилцаа, үзэсгэлэн, үзэгчдийн судалгаа, боловсрол, үнэлгээ, үйлчилгээ)-ний музей судлалын сэдэв, агуулгыг уялдуулан чиглүүлбэл зүйтэй байна.

Монголын музейн хөгжлийг музей судлалын онолын үзэл баримтлалын үүднээс авч үзвэл, XX зуунд музей нь нэг намын үзэл баримтлал, социалист үзэл суртлаар хүмүүжүүлэх, соён гэгээрүүлэх үүрэг хүлээж байв. Ингэхдээ музей байгуулах, музей эрхлэхэд бодлогын үзэл баримтлал, үзэл суртал, нөлөөлөл чухал байр суурьтай байна. Эндээс музей шинээр байгуулах, эрхлэх ажил нь хүний нөөц, төсөв хөрөнгө их шаарддаг болохыг Хувьсгалын, Театрын, Чойбалсангийн, Лениний, Парламентын, Төрийн түүхийн, Хэлмэгдэгсдийн, Шашны, Үлэг гүрвэлийн зэрэг олон музейн жишээнээс харж болох юм.

Дүгнэлт

Монголд эртний зүйлийн хамгаалалтыг 1918, музейн тодорхойлолт, судалгааг 1921, харилцааг 1921, музейн хүний нөөц, байгууллагыг 1923 оноос тус бүр, 1924 оны Үндсэн хуулиар музейн хөрөнгийн хэвшлийг анхлан зохицуулж, мөн онд анхны музей олон нийтэд үүд хаалгаа нээжээ. 1970 оны Түүх, соёлын дурсалт зүйлийг хамгаалах хуулиар сан хөмрөгийн хадгалалтыг зохицуулж, 1992 оноос музейг монголчуудын эрт эдүгээгийн түүх, соёл, дурсгалыг хадгалан хамгаалж, хойч үедээ өвлүүлэх, олон нийтэд сурталчлан таниулах нийгмийн үүрэг бүхий төрийн үйлчилгээний байгууллага хэмээн тодорхойлов. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Соёлын тухай хууль, Монгол Улсын музейн тухай хууль, бусад бодлогын баримт бичгүүд нь өнөөгийн музейн үзэл баримтлалын үндэслэл болж байна.

Монгол Улсын тулгуур үзэл баримтлал музейн үзэл баримтлал, үйл ажиллагаанд тод сайн байгаа боловч музейн хөгжил, музейн сан хөмрөгийг багтаасан бүхий л функц өөрсдийн бий болгосон ололт, туршлагаа ахиулан музей-нийгэм соёл, өв судлал, тогтвортой хөгжилд чиглэх шаардлагатай болж байна. Монгол Улсын музейн судалгаа, харилцаа, боловсролын талаарх эрх зүйн бодлогын баримт нь сан хөмрөг бүрдүүлэлтийн талаарх эрх зүй, бодлогын баримтаас харьцангуй цөөн байна. Энэ нь сан хөмрөг бүрдүүлэлтийг түлхүү анхаарч хөгжүүлж байгаа хэдий боловч сан хөмрөгийн цахим сан, хайлтыг үзэгч, олон нийтэд хүргэх ажил өнөө хүртэл эрх зүй, практикт буугаагүй, үүний суурь нэр, нэр томьёоны төрөлжүүлэл, ангилах зэрэг ажлууд хангалтгүй байгааг анхаарууштай. Музейн судалгаа, харилцаа, боловсролын чиг үүргийг хөгжүүлэх нэн шаардлагатай юм. Учир нь музейн судалгаа багатай үед боловсролын ажлын үр өгөөж бага, зорилтот бүлэг, хүртээмж мууддаг. Энэ үед музейн нийгэм, байгаль орчны талаарх шинэ хандлага, шинэ технологи, сан хөмрөг хадгалалтын ёс зүй, тактик, үзэсгэлэнгийн үнэн зөв ёс зүйтэй байдал, олон нийтийн оролцоо, насан туршийн боловсрол, олон өнгөт, дуу хоолойтой тайлбар, хүртээмж, нийгмийн үүрэг, хариуцлага хүлээх, бусад байгууллагатай харилцах (Davis Peter 2011, 64) нөөц, чадавх сул байдаг билээ.

Монголын музейн ирээдүйд шинэ музей судлалын онол, үзэл баримтлалыг нэвтрүүлэн нутагшуулах, үр дүнд шинжлэх ухааны үндэслэлтэй нийгмийн эрүүл мэнд, хүний амьдралын чанар сайжруулах, барилга барьж музейг байгуулахаас илүүтэй байгаль хүрээлэн буй хуурай эмзэг экосистемтэй орчинд ээлтэй музей урлах, дэглэх ур чадвар, мэдлэг сорьсон нөр их судалгаа, бүтээн байгуулалтын ажлын орон зай байна.

Ашигласан материалын жагсаалт

- Бумаа, Д. 2010. “Монголын музейн тогтолцооны хөгжлийн асуудалд.” *Монгол-Японы соёлын IY чуулган*. Улаанбаатар.
- Бүрнээ, Ө. 1994. *Монголын шинэ үеийн үндэсний музей: Түүхэн тэмдэглэл*. Улаанбаатар.
- Соёл урлаг судлалын хүрээлэн. 2015. *Монголын соёл урлагийн хувьсал, өөрчлөлт*. Улаанбаатар.
- Сүхбаатар, Д. 2014. “Монголын орчин цагийн музейн түүхэн хөгжил, цаашдын зорилт.” *Монголын музейн хөгжил, шинэчлэл-90 жил. Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл*. Эрх. Монголын үндэсний музей. Улаанбаатар.
- Цэдмаа, Д. 1997. “Музей судлалыг хөгжүүлэх нь музейн ажлын үндсэн зорилт.” *Монголын соёл урлаг судлалын симпозиум*. Эмх. Дэмчигсүрэн Д. Улаанбаатар.
- Цэндсүрэн, Д. 2005. “Монгол оронд музейн тогтолцоо үүсэж бүрэлдсэн нь.” *Монголын соёл урлаг судлал VII-VIII*: 191-201.
- Энхтөгс, Д. 2014. “Монголд музей судлал үүсэж хөгжсөн нь.” *Монголын музейн хөгжил, шинэчлэл-90 жил. Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл*. Эрх. Монголын үндэсний музей. Улаанбаатар.
- Гадаад хэлээр:**
- Davis, Peter. 2011. *Ecomuseums A Sense of Place*. Continuum International Publishing Group.
- Maroevic, Ivo. 1998. *Introduction to Museology - The European Approach*, Gary Edson, ed. English Edition. Munich: Verlag Dr. Christian Muller-Straten.
- Mensch, P. Van. 1992. “Toward a Methodology of Museology.” Doctor’s Thesis, University of Zagreb.